



МОНГОЛ УЛС  
ХЭНГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 1187

Чингис хот

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.16, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5, 14 дүгээр зүйлийн 14.4, 14.5, 14.7 дахь заалтууд, Батноров сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралдааны 2020 оны 12 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Батноров сумын нутаг дэвсгэрт Маль нэртэй 26.15 га талбайд “Мальфлюорит” ХХК-д Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгосугай.

2. Тусгай зөвшөөрөл олгосон тухай шийдвэрийг Ашигт малтмал, газрын тосны газрын кадастрын зураг зүйн нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх, аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газар /Б.Дархантөр/, Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/, Цагдаагийн газар /Б.Батсайхан/, Батноров сумын Засаг дарга /Г.Тайванжаргал/-д тус тус мэдэгдэж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Э.Мөнх-Эрдэнэ/-т даалгасугай.

3. Хайгуулын ажлын төлөвлөгөөг хуулийн хугацаанд багтаан батлуулж, үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд явуулах, холбогдох тайлан мэдээг цаг тухайд ирүүлж ажиллахыг “Мальфлюорит” ХХК-д зөвлөсүгэй.

4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжид хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг чанд мөрдүүлж, үйл ажиллагааны явцад хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/, Цагдаагийн газар /Б.Батсайхан/, Байгаль, орчин аялал жуулчлалын газар /Б.Дархантөр/-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА